

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын 2016 оны “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр батлах тухай” тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Тэргүүн ээлжинд боловсруулж, батлуулах шаардлагатай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн жагсаалт”-ын 1.3.5-д “Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах хууль, эрх зүйн орчныг сайжруулж, урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх” гэж, мөн жагсаалтын 1.3.7-д “Банк, санхүүгийн системийн нээлттэй, ил тод байдлыг хангаж, гадаадын банкны салбар нэгж нээн ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох”-оор тус тус заасан.

Дэлхийн эдийн засгийн интеграци эрчимжихийн хэрээр санхүүгийн зах зээлийн либералчлал улам тэлж энэ нь Монгол Улсын дотоодын банкны салбарт тусгалаа олж өнөөдрийн байдлаар дотоодын зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа 8 банкинд гадаадын хөрөнгө оруулалт ороод байна. 2008 оноос хойш олон улсын санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг, нэр хүнд бүхий гадаадын банкууд манай улсад төлөөлөгчийн газраа нээн ажиллуулж байна.

Монгол Улстай ижил төстэй харьцангуй жижиг, нээлттэй эдийн засаг бүхий улс орнуудын хувьд дотоодын зах зээлдээ гадаадын банкиг нэвтрүүлэх нь санхүүгийн салбарын интерацид нэгдэх, банк санхүүгийн салбарын хөгжлийг хурдасгахад онцгой ач холбогдолтой. Монгол Улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагад элсэхдээ санхүүгийн зах зээлийг нээлттэй болгох үүрэг хүлээсэн. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2.2 дах хэсэгт “Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална гэж заажээ.

Монгол Улсын хувьд гадаадын банк, санхүүгийн байгууллагад дотоодын банкинд хөрөнгө оруулж, хувь эзэмших хэлбэрээр нэвтэрсэн. Одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй нийт 14 банкнаас 8 банк гадаадын хөрөнгө оруулалттай байгаа бол эдгээрээс 3 банк гадаад банкны хувьцаа эзэмшигчтэй байна.

Гадаад банк Монгол Улсад байгуулагдах, банкны үйл ажиллагаа явуулах талаарх харилцааг Банкны тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай, Компанийн тухай хууль болон Монголбанкны Банкны зөвшөөрлийн журам, Банкны нэгжийн журмаар зохицуулж байна. Монголбанкны Банкны зөвшөөрлийн журамд заасны дагуу дээрх төлөөлөгчийн газрууд нэгээс доошгүй жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулсан бол банкны үйл ажиллагааг эрхлэх хүсэлтээ Монголбанк болон бусад эрх бүхий байгууллагуудад тавих эрхтэй байгаагаас гадна Банкны нэгжийн журамд зөвхөн гадаадын банкны төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл олгох, татгалзах, түтгэлзүүлэх, хүчингүй болгох тухай асуудлыг

журамласнаас өөрөөр гадаадын банкны талаар нарийвчилсан зохицуулалт Банкны тухай хууль тогтоомжид одоогоор байхгүй байна.

Иймд гадаадын банкиг зөвхөн хөрөнгө оруулалтын чиглэлээр дотоодын зах зээлд нэвтрэхийг зөвшөөрөх, ингэхдээ томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд шаардлагатай зээлийг гагцхүү хуулийн этгээдэд олгох, гадаад дотоодын төлбөр тооцоог гүйцэтгэх, зээлийн баталгаа, батлан даалт гаргах, үнэт цаас худалдах, худалдан авахыг зөвшөөрч, бусад үйл ажиллагааг тэр тусмаа иргэдийн хадгаламж авах зэргийг хориглосон хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох зайлшгүй шаардлагатай болоод байна.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засагт дараах эерэг нөлөө үзүүлнэ гэж тооцож байгаа болно:

- Шинэ технологи нэвтрэх. Хөгжиж буй улс орнуудын банкны ГХО нэмэгдэх нь хүмүүн капитал, шинэ технологийг зах зээлд нэвтрүүлж, боловсон хүчний мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ;
- Зах зээл дэх өрсөлдөөн нэмэгдэх. ГХО-тай банк нэмэгдэх нь банкны системийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж, улмаар банкны бүтээмж өсч, зээлийн хүү буурна;
- Зээл хуваарилалтын үр ашиг нэмэгдэх. ГХО-тай банк зах зээлд нэвтэрснээр хамаатай этгээдэд олгосон зээлийн хэмжээ буурч, зохих журмын дагуу дотоодын захад зээл олголт хийгдэнэ;
- Дотоодын санхүүгийн зах зээлийн хөгжилд түлхэц үзүүлэх. ГХО-тай банк нь санхүүгийн үүсмэл хэрэгсэл, хувьцаа эргийг ашиглан үйл ажиллагаа эрхлэх туршлага дотоодын банкуудаас илүү буюу мэргэшсэн байдаг нь тэдгээрийг зах зээлд санхүүгийн шинэ бүтээгдэхүүн нэвтэрнэ;
- Дотоодын зах зээлийн тогтвортой байдал нэмэгдэх. Урт хугацаанд дотоод, гадаадын банкуудын эрсдэлийн удирдлагын тогтолцоо нэг түвшинд хүрснээр чанаргүй зээлийн хэмжээ буурч, зээлийн багцын удирдлага сайжирна;
- Санхүүгийн системийн дэд бүтэц сайжрах. Өндөр хөгжилтэй орнуудын банкны системийн сайн туршлага, ноу-хоу, бүртгэл, ил тод байдал, санхүүгийн зохицуулалт, зөвлөгөө өгөх чадвар дотоодын зах зээлд төлөвшинэ;
- Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх. Хэрэв гадаадын банкууд салбарууд олноор байгуулах, орчин үеийн онлайн, мобайл банкны үйлчилгээ нэвтрүүлэх тохиолдолд санхүүгийн үйлчилгээний хүртээмж сайжирна;
- Валютын урсгалыг сайжруулах, хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зэргээр богино хугацаанд эерэг нөлөөтэй. Эдийн засгийн хүндрэлтэй үед хэт өндөр биш дүнтэй багцын дотогшлох урсгал нь дунд хугацаанд эерэг нөлөө үзүүлнэ.